

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2018.02.23-2018.03.23/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 15-р хуралдаан болж 8 асуудал, Тэргүүлэгчдийн 6,7,8-р хуралдаан болж 13 асуудлыг тус тус хэлэлцлээ.

Сумын 2018 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд батлагдсан зүүн гэр байрны зүүн талын байршилд иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын гудамжны нэрийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн “Ургах” гэж нэрлэхээр 2018 оны 12 дугаар тогтоолоор баталсан.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 2 байршилд иргэдээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын өргөдлийг 2018.03.19-ний өдрийн 10:00 цагаас авч 2018.03.22-ний өдөр хүртэл авч дууссан. Нийт 250 иргэнд 26.5 га газар өмчлүүлэхээр хүсэлт ирүүлсэн.

- Зөрлөг хороололд /авто зам дагуу/-14 га-200 иргэнд
- Ургах хороололд-12.5 га -50 иргэнд



2018 оны 03-р сарын 21-ний өдөр ЗДТГ-ын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн, Хөдөлмөр халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нар сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хурлыг зохион байгуулан тэдний санал бодлыг нь сонсож 2018 онд хийх ажлын төлөвлөгөөг танилцуулан мөн хөгжлийн бэрхгээтэй иргэдийн тэргүүн, тэргүүлэгчдийг сонгосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргүүнээр А.Эрдэнэчулуун, тэргүүлэгчдээр Б.Баянжаргал, О.Төрбат, Р.Оюунбилэг, Ц.Өлзийбуян нарыг 100 хувийн саналаар сонгож баталгаажуулсан.

2018 оны 03 дугаар сарын 22-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулж буй Сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, сум, багийн Засаг дарга нарын сургалтанд хамрагдаж Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, сумын дэд хөтөлбөр боловсруулахад анхаарах асуудал, Төсвийн өнөөгийн нөхцөл, байдал, анхаарах асуудал, нийгмийн салбарт хэрэгжиж буй дэд хөтөлбөр, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналт, Барилгын ажлын чанар, стандарт, зураг, төсвийн боловсруулалт, сум, орон нутгийн 2017 оны нийгэм, эдийн засгийн танилцуулга зэрэг сэдвүүдээр мэдээлэл авлаа. Мөн тус сургалтын үеэр сумдын дунд нөхөрсөг тэмцээн зохион

байгуулагдсан бөгөөд сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй,эмэгтэй баг тамирчид тус тус 2-р байр эзэллээ.

ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2018 оны 03-р сарын 22-ны өдрийн байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	10921500	10771500
2.	ЗДТГ	82990100	79200600

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /төгрөгөөр/	Зардлын гүйцэтгэл /төгрөгөөр/
1.	Эрүүл мэндийн төв	90558800	88785800
2.	Соёлын төв	16333000	15983800
3.	3-р сургууль	190507400	186428600
4.	3-р цэцэрлэг	108354700	98960580

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 03-р сарын 23-ны байдлаар 9 646 400 төгрөг бөгөөд гүйцэтгэл 3 922 759 төгрөг буюу 41 хувийн биелэлттэй байна.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Хууль зүйн орон тооны бус албаны 2018 онд зохион байгуулах эрх зүйн албан бус сургалтын төлөвлөгөөний дагуу 2018 оны 03 сарын 19-ний өдөр Монголын хүний нөөцийн удирдлага шинэчлэлийн академийн сургагч багштай хамтран сумын нийгмийн салбарын байгууллагуудын 110 ажилтан, албан хаагчдад “Хувь хүний хөгжил, хандлага”, 3-р сургуулийн 11, 12 дугаар ангийн 104 сурагчдад “Манлайллын ур чадвар” сэдэвт лекцүүдийг зохион байгууллаа.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын 1 дүгээр улирлын биелэлтийг гаргаж аймгийн ТЗУХ-т хүргүүлсэн.




Бодлогын баримт бичгүүдээс суманд хэрэгжих заалтуудыг хяналтанд авч нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан батлуулан ажиллаж байна.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ


3-Р СУРГУУЛЬ :

Аймгийн ЭЕШ-ын судлагдахуунуудын чиглүүлэгч багш нар 2018 оны 2 дугаар сарын 27-ний өдөр 3-р сургууль дээр ирж ажиллан ЭЕШ-ын шалгалтанд хэрхэн бэлтгэж байгаатай танилцаж багш нар болон төгсөгчдөд зөвлөгөө өгч ажиллалаа.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд ЭЕШ-ын амжилтыг ахиулахын тулд судлагдахуунуудын чиглүүлэгч багш нар Монгол хэл, Математик, Англи хэл, Хими, Биологи, Физик, Нийгмийн ухааны хичээлүүдийн сорилго шалгалтыг авч дүнг сургуулиудад зөвлөмжийн хамт хүргүүлсэн бөгөөд сорилгын дүнг хичээл тус бүрээр сургуулиудын дундаж оноог графикаар харьцуулж харуулбал:



“САЙН БАГШИЙН САЙН ШАВЬ” ажлын хүрээнд бага ангийн V бүлэгийн нийт 66 сурагчдаас хаврын улсын шалгалтанд бэлтгэх зорилгоор математик, монгол хэл, байгалийн ухааны хичээлээр сорилго шалгалтыг зохион байгуулж үр дүнг нэгтгэлээ.



Бага ангийн хэмжээнд хэрэгжиж буй “Бяцхан судлаач” төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор бага ангийн багш нарын бичиг баримт, нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт, хичээлийн бэлтгэл болон багш нарын заах арга зүйд зөвлөн тусалж ажиллалаа.


Говьсүмбэр аймагт зохион байгуулагдсан Орос хэлний хичээлийн төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд 4 сурагч 1 багш оролцсоноос орос хэлний багш С.Эрдэнэчимэг 2 дугаар байр, 12 дугаар ангийн сурагч Г.Сергей, Н.Оролмаа нар 1, 2 дугаар байрыг эзэлж, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан 3-ын даваанд оролцон Г.Сергей 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль хүртэн цаашид ОХУ-ын Ломоносовын нэрэмжит Москвагийн Их Сургуульд үнэ төлбөргүй суралцах эрхээр шагнагдлаа.

“Монголоороо гоёе” өдөрлөгийг 2018 оны 02 сарын 26-наас 02 сарын 28-ны өдрүүдэд бага, дунд, ахлах анги, багш ажилчдын дунд гэсэн 4 ангиллаар зохион явуулж, Монгол ардын уламжлалт оюун ухаан, авхаалж самбаа шалгасан тэмцээн, уралдаануудаар шилдгүүдээ шалгарууллаа.

Сурагчдын чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэх, дуулах ур чадварыг нь хөгжүүлэх зорилгоор “Аав, ээжийн тухай дууг хэн сайн дуулах вэ?” уралдааныг 2018 оны 03 сарын 05 өдөр сургууль дээрээ зохион байгууллаа. Уг тэмцээнд I – IX ангийн нийт 17 суралцагч оролцлоо.

СОЁЛЫН ТӨВ

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Есөн цагаан цацал-4” тоглолтыг 2018 оны 03 сарын 08-ны өдөр зохион байгууллаа.



Зэвсэгт хүчний 97 жилийн ой, эр цэргийн баярыг тохиолдуулан 03 дугаар сарын 18-ны өдөр сумын Соёлын төвийн дэргэдэх цахилгаан хөгжмийн хамтлаг, уран бүтээлчдийн урлагийн тоглолт, цэнгүүнийг зохион байгууллаа.

3-Р ЦЭЦЭРЛЭГ

3-р цэцэрлэгт шинээр туршин нэвтрүүлж буй арга зүйн технологийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ахлах, бэлтгэл бүлгүүд STEAM хөтөлбөрийн сэдвийн тайлангаа эцэг эхчүүдэдээ тавьж, 5 бүлгийн 40 гаруй хүүхэд үзэж танилцсан сэдвээрээ илтгэл тавьлаа.

Цэцэрлэгийн ЗАН-ээс санаачлан ахлах, бэлтгэл бүлгүүдийн эцэг эх, хүүхдүүдийн дунд “Шагайн наадам-2018”-ыг шагай шүүрэх, 4 бэрх хаях, морь уралдуулах, шагай таалцах, алаг мэлхий өрөх гэсэн 5 төрлөөр зохион байгууллаа.

3-р цэцэрлэгийн санаачилгаар 2018 оны 03 сарын 03-ны өдөр Хаялга нуурын эрэг дээр “Цасны баяр”-ыг зохион байгуулж, аймгийн 5 цэцэрлэг, БСУГ-ын 4 багуудын хооронд 5 төрлийн уралдаан тэмцээн явуулж, шилдгүүдээ шалгаруулсан.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

- Эмнэлэгт хэвтсэн- 56 үүнээс хүүхэд- 22 дотор- 34
- Амбулаторийн үзлэг – 461
- Урьдчилан сэргийлэх
- Дуудлага-143

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний материал, эм тариа хүрэлцээтэй байна.

Нийгмийн эрүүл мэндийн ажлын хүрээнд:


“Миний гэр аюулгүй орчин, Осолгүй орчин” аяны хүрээнд 2018 оны 02 сарын 26, 27-ны өдрүүдэд хүүхдийн эсэн мэнд өсөн торних аюулгүй орчин бүрдүүлэх, болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, мэдлэгийг олгох сургалт зохион байгуулж, 2 настай хүүхэдтэй нийт 54 эцэг эх хамрагдлаа. Мөн тус аяны хүрээнд үзүүлэн таниулах самбарыг суманд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаар аялуулж, иргэдэд сурталчиллаа.

Тус аяныг өрнүүлэх үеэр эцэг эхчүүд осол гэмтэлд өртөх эрсдэлтэйг мэддэг боловч эрсдэлт зан үйлээ өөрчлөх ямар нэгэн алхам хийдэггүй нь ажиглагдсан тул сумын Эрүүл мэндийн төвөөс санаачилан 10 өрхөд цахилгааны утас, цахилгааны залгуурыг хүүхдээс хамгаалсан хайрцаг, утас тогтоогч хамгаалалтуудыг хийж өгч, бусад эрсдлүүдээ арилгахыг зөвлөн ажиллалаа.



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ

2018 оны 03-р сард ажил хайгчаар 12 иргэнийг ажил хайгчаар бүртгэж программд оруулсан. 2018 он 03-р сарын 18-ны өдрийн байдлаар 1 иргэнийг Засаг даргын Тамгын газарт, 6 иргэнийг Шивээ-Овоо ХК-д нийт 7 иргэнийг ажилд зуучиллаа.



БНСУ-д хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу 2018 оны 14 дэх удаагийн солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлд 2018 оны 03-р сарын 5-7нд Говьсүмбэр аймгийн ХХҮГ-т зохион байгуулагдсан. Энэхүү бүртгэлд иргэдийг хамруулах ажлын хүрээнд сумын мэдээллийн самбарууд болон олон нийтийн сүлжээгээр зарлалыг байршуулан ажилласан.

2018 онд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжих хөтөлбөрүүдийн хүрээнд төсөл хүлээн авах зарыг мэдээллийн самбарууд болон олон нийтийн сүлжээгээр зарлалыг байршуулан ажилласан.

2017 онд хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн эргэн төлөлтийг цаг хугацаанд нь хийлгэх, нийгмийн даатгалд хамрагдах талаар холбогдож тухай бүр сануулан сарын хийсэн ажлын тайланг хүлээн авч төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.

2018 оны 03-р сарын 16, 20-ны өдрүүдэд Шивээговь сумын “Хүнсний эрхийн бичиг”-ийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 12 өрхийн 74 гишүүнд 1-3-р сарын 2696000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээ байгуулсан “Энх-Оюу” дэвжих ХХК-ийн дэлгүүрээр дамжуулан олголоо.

УЛСЫН БҮРТГЭЛ

2018 оны 2 дугаар сарын 22-ноос 2018 оны 3 дугаар сарын 22-ны байдлаар Иргэний бүртгэлийн үйлчилгээг 75 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 9 иргэнийг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

2018 оны 03 дугаар сард газраа анх удаа өмчилж авч байгаа 2 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Эхний 3 сарын өссөн дүнгээр 12 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аймаг орохгүйгээр сумаасаа аваад байна.

Иргэдээс энэ сард 62 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2018 ОНЫ 03 САРЫН МЭДЭЭ

	м/ д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	23				23	8	15
Төрсөн эх	2	23				23		23
Бүртгүүлсэн гэр бүл	3	9				9	9	9
Нас баралт	4	4				4	2	2
Цуцалсан гэр бүл	5	3				3	3	3
Үрчлэгдсэн хүүхэд	6	0				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	31				31	14	17
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	23				23	15	8

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2018 оны 03-р сар			Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд	Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд		

		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Эцэг тогтоосны бүртгэл	2500	3	7500				
2	Гэрлэлтийн гэрчилгээний үнэ	2500	3	7500				
3	Иргэний үнэмлэхний үнэ	15000	12	180000	3300	12	39600	
	Нийслэл шилжин явсан	5000	1	5000	1000	1	1000	
	Өөр аймаг шилжин явсан	2500	7	17500	1000	7	7000	
4	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	1500	11	16500	1000	11	11000	
ДҮН		241500			58600			
НИЙТ ДҮН		300100						

МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ

2018 оны 03-р сарын байдлаар хорогдсон малын тоо 331, үүнээс адуу-41, үхэр-27, хонь-85, ямаа-155 байна. 2018 оны 03-р сарын байдлаар ишиг-293, хурга-349, тугал-19 нийт 647 төл бойжиж байна.

Орчны бохирдлоос шалтгаалсан аливаа халдварт өвчин гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа үхсэн мал, амьтны сэг зэмийг устгах ажлыг багийн Засаг дарга, МЭҮТ-тай хамтран зохион байгуулж 6 төрлийн 295 мал, амьтны сэмийг ариутгал, халдваргүйтгэлийг хийж булж устгасан бөгөөд ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

БАЙГАЛЬ ОРЧИН

2018 оны 03 дугаар сарын 21-ний өдөр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Сум дундын Ойн анги зэрэг байгууллагууд тус салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор Шивээговь суманд "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг зохион байгууллаа.

"Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийн үеэр сумын удирдлагуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулж 2018 онд байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого, үйл ажиллагааны хүрээнд хэрхэн хамтран ажиллах талаар чиглэл өгч, санал солилцлоо. Мөн "ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР", "ЦАГ УУРЫН ӨДӨР", "ОЛОН УЛСЫН ОЙН ӨДӨР"-үүдийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сурагчдын дунд танин мэдэхүйн хөгжөөн цэнгээнт "АХА" тэмцээнийг зохион байгуулж 70 сурагч хамрагдсан байна.



Нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах хуваарийн дагуу бүх нийтийн их цэвэрлэгээг 03 сарын 16-ны өдөр зохион байгуулж 17 аж ахуйн нэгж, байгууллагын 105 иргэн хамрагдаж 20м³ хог хаягдлыг цэвэрлэж хогийн цэгт төвлөрүүлээ.



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2018 оны 04 тоот тогтоолоор сумын ундны усны эх үүсвэр /Алсын 1, 2-р худаг/-ийн 33 га талбайг 30 жилийн хугацаатайгаар орон нутгийн тусгай хамгаалалтад авлаа.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 04 дугаар тогтоолоор 2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн 173,177,800 төгрөгийн хөрөнгөөр 21 ажил, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2018 оны 3 дугаар сарын байдлаар 2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн 15 сая төгрөгийн хөрөнгөөр “Ахуйн хог хаягдал тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн хогийг цэвэрлэж булах ажил”-ын гүйцэтгэгчээр “Илчлэг Шивээ” ОНӨҮГ шалгарч гэрээ байгуулан ахуйн хог хаягдал тээвэрлэх ажлыг гүйцэтгүүлж байна. Урьдчилгаа 6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн 50 сая төгрөгийн хөрөнгөөр Эрүүл мэндийн төвд эхо томографик 4D аппарат худалдан авах барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж 2018 оны 02 дугаар сарын 28-ний өдөр тендерийг цахимаар зарлан 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдөр нээсэн.

Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/27 захирамжаар 3-р сургуулийн цахилгааны монтажийг хэсэгчлэн шинэчлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгууллаа.

Мөн өвс тэжээлийн нэгдсэн фондыг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж иргэн Б.Баяртогтохтой 714 боодол өвсийг 5 997 600 төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулан өвсийг хүлээж авсан.

Сумын Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Золбин нохой, муур устгах ажлыг зохион байгуулах комисс томилогдож 2018 оны 03 дугаар сарын 21-нд иргэн Ш.Зоригтбаатартай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлж байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ДАХОХААХМэргэжилтэн:

С.БАНЗРАГЧ